

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/657/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд  
Утас: 7000-7734 Цахим хаяг: [boldch@audit.gov.mn](mailto:boldch@audit.gov.mn)

Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр  
Утас: 315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Отгонбаяр  
Утас: 315558 Цахим хаяг: [otqonbayarda@audit.gov.mn](mailto:otqonbayarda@audit.gov.mn)

Аудитор: Д.Баасанням  
Утас: 325093 Цахим хаяг: [baasannyamd@audit.gov.mn](mailto:baasannyamd@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг .ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54

И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

№ 02-25 № 01/179  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН  
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,  
ХАМГААЛЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Н.ХӨХӨӨ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь хүүхдийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн хүрээнд эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх гэсэн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр төсвийн төслийг боловсруулахдаа тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг судалж, нөхцөл байдал, эрсдэлийг үнэлээгүй, шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд хамтарсан багийн гишүүдийг ажлын байранд чадавхжуулах, зорилтод бүлэгт гэр бүлийн боловсрол олгох, архины хамааралтай иргэдийн зан үйлийг засах, хууль сурталчлан таниулах, тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг сургалт зохион байгуулж төсвөөс 187,293.5 мянган төгрөг зарцуулсан боловч сургалтын үр дүнг тооцоогүй, цаашдын сургалтын хэрэгцээг тодорхойлоогүй байна.

### Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 83.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан

02023877

C:\Users\zendmeme\Desktop\02025\Word\Tvyvan bichig\02025.02.25.SHD-H08HRH.docx

байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>102,015,472.95</u></b>	<b><u>67,490,459.27</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	102,015,472.95	67,490,459.27
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	102,015,472.95	67,490,459.27
35410	Бичиг хэргийн материал	1,125,192.00	229,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,966,000.00	2,026,700.00
35470	Бусад хангамжийн материал	95,924,280.95	65,234,759.27
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>271,551,830.16</u></b>	<b><u>309,283,373.00</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	271,551,830.16	309,283,373.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	259,136,580.16	296,868,123.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	25,000,000.00	25,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,651,000.07)	(11,776,000.11)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,615,873.11	225,022,873.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,940,810.10)	(69,489,318.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	189,111,484.68	189,111,484.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,998,967.46)	(61,000,915.90)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	12,415,250.00	12,415,250.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,115,250.00	15,115,250.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,700,000.00)	(2,700,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>373,567,303.11</u></b>	<b><u>376,773,832.27</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>4,440,645.55</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	4,440,645.55
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	4,440,645.55
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	4,440,645.55
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>373,567,303.11</u></b>	<b><u>372,333,186.72</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	373,567,303.11	372,333,186.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,415,250.00	12,415,250.00
51101	Өмч: - төрийн	12,415,250.00	12,415,250.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	361,152,053.11	359,917,936.72
51210	Өмнөх үеийн үр дүн	28,324,374.02	361,152,053.11
51220	Тайлант үеийн үр дүн	332,827,679.09	(1,234,116.39)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>373,567,303.11</u></b>	<b><u>376,773,832.27</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,684,713,237.67</b>	<b>2,488,347,995.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>329,294,379.67</b>	<b>60,078,566.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	329,294,379.67	60,078,566.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	328,790,100.67	60,074,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	328,790,100.67	60,074,000.00
120009	Бусад орлого	504,279.00	4,566.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,355,418,858.00</b>	<b>2,428,269,429.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	493,978,500.00	1,322,446,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	493,978,500.00	1,322,446,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	861,440,358.00	1,105,822,829.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	857,103,658.00	1,101,265,529.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,336,700.00	4,557,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,351,885,558.58</b>	<b>2,489,582,111.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,351,885,558.58</b>	<b>2,489,582,111.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,085,456,615.68	2,244,953,671.32
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	365,958,954.44	770,095,359.07
210101	Үндсэн цалин	230,387,348.23	446,180,961.46
210102	Нэмэгдэл	52,253,972.28	147,502,660.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,906,520.34	115,696,037.00
210104	Урамшуулал	29,902,855.53	58,915,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,508,258.06	1,800,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,874,286.90	64,701,343.68
210201	Тэтгэврийн даатгал	34,964,093.74	42,282,332.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,491,260.36	4,996,795.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,864,033.92	3,535,597.03
210204	Ажилгүйдлийн даатгал	409,519.05	2,805,351.31
210205	Эрүүл мэндийн даатгал	4,145,379.83	11,081,266.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,931,285.63	9,188,373.87
210301	Гэрэл, цахилгаан	1,896,501.63	5,218,468.48
210303	Цэвэр, бохир ус	1,034,784.00	3,969,905.39
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,106,599.01	74,114,184.46
210401	Бичиг хэрэг	4,660,762.44	4,502,550.00
210402	Тээвэр, шатахуун	1,445,000.00	10,980,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,176,686.57	2,035,075.46
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	690,000.00	760,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,134,150.00	55,836,559.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	29,796,745.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,952,835.00
210502	Хоол, хүнс	-	16,843,910.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	11,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	110,000.00	4,087,000.00
210604	Урсгал засвар	110,000.00	4,087,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	637,319,413.62	1,232,835,208.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	635,198,403.62	1,230,556,234.08
210803	Даатгалын үйлчилгээ	473,010.00	73,100.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	657,000.00	213,874.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	448,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,320,000.00
210807	Газрын төлбөр	543,000.00	650,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,156,076.08</b>	<b>60,135,457.16</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,376,138.00	2,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	660,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,479,938.08	56,675,457.16
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>266,428,942.90</b>	<b>244,628,440.07</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,150,000.00</b>	<b>927,900.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,150,000.00	927,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>265,278,942.90</b>	<b>243,700,540.07</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	265,278,942.90	243,700,540.07
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>332,827,679.09</b>	<b>(1,234,116.39)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>332,827,679.09</b>	<b>(1,234,116.39)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,355,418,858.00</b>	<b>2,428,273,995.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>4,566.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	4,566.00
120009	Бусад орлого	-	4,566.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,355,418,858.00</b>	<b>2,428,269,429.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	493,978,500.00	1,322,446,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	493,978,500.00	1,322,446,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	861,440,358.00	1,105,822,829.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	857,103,658.00	1,101,265,529.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,336,700.00	4,557,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,353,972,358.00</b>	<b>2,393,940,995.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,353,972,358.00</b>	<b>2,393,940,995.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,087,543,415.10</b>	<b>2,149,312,554.93</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	384,018,265.14	770,095,359.07
210101	Үндсэн цалин	248,446,658.93	446,180,961.46
210102	Нэмэгдэл	52,253,972.28	147,502,660.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,906,520.34	115,696,037.00
210104	Урамшуулал	29,902,855.53	58,915,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,508,258.06	1,800,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,874,286.90	60,260,698.13
210201	Тэтгэврийн даатгал	34,964,093.74	41,921,720.70
210202	Тэтгэмжийн даатгал	2,491,260.36	4,996,795.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,864,033.92	2,622,248.19
210204	Ажилгүйдлийн даатгал	409,519.05	1,805,634.91
210205	Эрүүл мэндийн даатгал	4,145,379.83	8,914,298.47
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,931,285.63	9,188,373.87
210301	Гэрэл, цахилгаан	1,896,501.63	5,218,468.48

210303	Цэвэр, бохир ус	1,034,784.00	3,969,905.39
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,800,203.01</b>	<b>37,790,445.46</b>
210401	Бичиг хэрэг	3,352,990.44	9,943,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,372,900.00	8,010,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,676,661.57	2,035,075.46
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	690,000.00	760,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,707,651.00	17,041,670.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>32,481,008.42</b>	<b>52,046,305.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	656,319.42	2,024,885.00
210502	Хоол, хүнс	16,988,889.00	19,225,420.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,835,800.00	30,796,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>35,433,489.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	15,734,000.00
210604	Урсгал засвар	-	19,699,489.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>558,498,366.00</b>	<b>1,181,037,884.40</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	556,107,856.00	1,177,711,210.40
210803	Даатгалын үйлчилгээ	473,010.00	73,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	926,500.00	292,874.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	448,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,288,700.00
210807	Газрын төлбөр	543,000.00	650,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>45,940,000.00</b>	<b>3,460,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,640,000.00	2,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	660,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>266,428,942.90</b>	<b>244,628,440.07</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,150,000.00</b>	<b>927,900.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,150,000.00	927,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>265,278,942.90</b>	<b>243,700,540.07</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	265,278,942.90	243,700,540.07
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,446,500.00</u></b>	<b><u>34,333,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,446,500.00</b>	<b>34,333,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,446,500.00</b>	<b>34,333,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,446,500.00</b>	<b>34,333,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,446,500.00	34,333,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,446,500.00)</u></b>	<b><u>(34,333,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>(0.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>(0.00)</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	рын оруулсан питал	дсан дүн	газрын хувь оны нийт дүн
<b>р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	12,415,250.00	324,374.02	40,739,624.02
дох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
<b>хийлсэн үлдэгдэл</b>	<b>12,415,250.00</b>	<b>324,374.02</b>	40,739,624.02
нгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
нгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
йланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
йн үр дүн	-	827,679.09	332,827,679.09
<b>2-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,415,250.00</b>	<b>152,053.11</b>	373,567,303.11
<b>р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>12,415,250.00</b>	<b>152,053.11</b>	373,567,303.11
дох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
<b>хийлсэн үлдэгдэл</b>	<b>12,415,250.00</b>	<b>152,053.11</b>	373,567,303.11
нгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
нгийн өсөлт, бууралт	-	-	-
йланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
отын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
йн үр дүн	-	234,116.39	(1,234,116.39)
<b>2-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,415,250.00</b>	<b>917,936.72</b>	372,333,186.72

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,322,446,600.00	1,159,278,504.24	163,168,095.76	87.7
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,322,446,600.00	1,159,278,504.24	163,168,095.76	87.7
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,321,518,700.00	1,158,350,604.24	163,168,095.76	87.7
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	508,548,300.00	382,049,159.68	126,499,140.32	75.1
210101	Үндсэн цалин	296,874,500.00	251,421,291.68	45,453,208.32	84.7
210102	Нэмэгдэл	148,674,500.00	41,399,746.00	107,274,754.00	27.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,311,800.00	56,426,722.00	-23,114,922.00	169.4
210104	Урамшуулал	29,687,500.00	31,001,400.00	-1,313,900.00	104.4
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	1,800,000.00	-1,800,000.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	63,568,600.00	45,839,510.36	17,729,089.64	72.1
210201	Тэтгэврийн даатгал	43,226,600.00	31,790,387.80	11,436,212.20	73.5
210202	Тэтгэмжийн даатгал	5,085,500.00	3,824,278.94	1,261,221.06	75.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,542,800.00	2,045,889.64	496,910.36	80.5
210204	Ажилгүйдлийн даатгал	2,542,800.00	1,501,574.57	1,041,225.43	59.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,170,900.00	6,677,379.41	3,493,520.59	65.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,421,500.00	12,322,851.80	1,098,648.20	91.8
210401	Бичиг хэрэг	3,943,000.00	3,943,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,210,700.00	3,210,700.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,834,300.00	735,651.80	1,098,648.20	40.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,433,500.00	4,433,500.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	26,867,000.00	26,684,000.00	183,000.00	99.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,924,000.00	23,742,000.00	182,000.00	99.2
210604	Урсгал засвар	2,943,000.00	2,942,000.00	1,000.00	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	708,408,900.00	690,795,082.40	17,613,817.60	97.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	703,020,600.00	687,665,408.40	15,355,191.60	97.8
210803	Даатгалын үйлчилгээ	73,100.00	73,100.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,100.00	95,874.00	226.00	99.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,000.00	22,000.00	2,000.00	91.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,288,700.00	2,288,700.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	2,906,400.00	650,000.00	2,256,400.00	22.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	704,400.00	660,000.00	44,400.00	93.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	704,400.00	660,000.00	44,400.00	93.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	927,900.00	927,900.00	-	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	927,900.00	927,900.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	927,900.00	927,900.00	0.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,322,446,600.00	1,159,278,504.24	163,168,095.76	87.7

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,322,446,600.00	1,159,273,938.24	163,168,097.76	87.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,322,446,600.00	1,159,273,938.24	163,168,097.76	87.7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	12.00	8.00	60.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	10.00	8.00	55.56
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,025,294,950.69</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,025,294,950.69</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,025,294,950.69
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	388,046,199.39
210101	Үндсэн цалин	194,759,669.78
210102	Нэмэгдэл	106,102,914.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,269,315.00
210104	Урамшуулал	27,914,300.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,421,187.77
210201	Тэтгэврийн даатгал	10,131,332.90
210202	Тэтгэмжийн даатгал	1,172,516.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	576,358.55
210204	Ажилгүйдлийн даатгал	304,060.34
210205	Эрүүл мэндийн даатгал	2,236,919.06
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,188,373.87
210301	Гэрэл, цахилгаан	5,218,468.48
210303	Цэвэр, бохир ус	3,969,905.39
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,467,593.66
210401	Бичиг хэрэг	6,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,299,423.66
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	760,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,608,170.00
2105	<b>Нормативт зардал</b>	52,046,305.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,024,885.00
210502	Хоол, хүнс	19,225,420.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,796,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	43,082,489.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,325,000.00
210604	Урсгал засвар	16,757,489.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	490,242,802.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	490,045,802.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,800,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,105,822,829.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,105,822,829.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,101,265,529.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,557,300.00

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35,042.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсний 20,042.0 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 15,000.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 35,042.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Төсвийн хөрөнгөөр 20,042.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авахдаа худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг зогсоох албан шаардлага өгөв.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Байгууллагыг сурталчлах зорилгоор 15,000.0 мянган төгрөгийн видео бичлэг хийлгэснийг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, материалыг орлогод авч бүртгэж байх;

#### 2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Хэлтсийн дэргэдэх “Түр хамгаалах” байрны газар, барилгыг өөрийн эзэмшилд аваагүй байна. Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх”, санхүүгийн тайлангийн “оршин байх” “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Хэлтсийн дэргэдэх "Түр хамгаалах" байрны газар, барилгыг өөрийн эзэмшилд авах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хэлтсийн дэргэдэх "Түр хамгаалах" байрны газар, барилгыг өөрийн эзэмшилд аваагүй байна.	1						1					
Үндсэн хөрөнгө /скайнер, процессер/-ийн худалдан авалт хийхдээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалгүй шууд гэрээ байгуулсан.	1	20,042.0			1	20,042.0						
Байгууллагыг сурталчлах зорилгоор видео бичлэг хийлгэснийг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.	1	15,000.0					1	15,000.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>35,042.0</b>			<b>1</b>	<b>20,042.0</b>	<b>2</b>	<b>15,000.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	390,601.8					1	390,601.8
Төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулаагүй, мэдээлээгүй байна.	1						1	
"Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх" хөтөлбөр, арга хэмжээний 2024 оны төсвийн төслийг боловсруулахдаа хэрэгцээ шаардлагыг үндэслээгүй, суурь судалгаа, шинжилгээ хийгээгүй, эрсдэлийг үнэлээгүй, шалгуур үзүүлэлт тодорхойлоогүй, тооцооллын хамт хүргүүлээгүй байна.	1						1	
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>390,601.8</b>					<b>3</b>	<b>390,601.8</b>

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
	Нийт	1	1			1			